

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ШИЙДВЭР**

2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн дүрэм шинэчлэн батлах,
Хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “компани”) нь нийт гаргасан энгийн хувьцааныхаа 25 хувийг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд амжилттай арилжаалж, нээлттэй хувьцаат компани болсныг дурдсугай.
2. Компани нь нэг бүр нь 10 (Арван) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800’000’000 (Найман зуун сая) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 8’000’000’000 (Найман тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг баталгаажуулсугай.
3. “ЛэндМН ББСБ Хувьцаат компанийн Дүрэм”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
4. Шинэчилсэн Дүрмийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч (М.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.
5. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ШИЙДВЭР**

2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “компани”)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Дүгэрсүрэн овогтой Бат-Очир
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Нармандах овогтой Цэвэгмид
 - 1.1.4. Монгол Улсын иргэн Баянжаргал овогтой Дэлгэржаргал
 - 1.1.5. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
 - 1.1.6. Монгол Улсын иргэн Володья овогтой Баярсайхан
 - 1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Булган овогтой Гантулга
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
 - 1.2.3. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зэрэг компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаархи мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч (М.Түвшинжаргал)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ч.Намираа)-д даалгасугай.

